



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 630

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.4, 6.6 дахь заалт, 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Говь-Алтай аймаг дахь Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, гурван удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй нийт 7,382,270.00 (долоон сая гурван зуун наян хоёр мянга хоёр зуун далан) төгрөгийн балансын анхны үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Цаг уур орчны шинжилгээний газрын дарга С.Энхтувшин, Говь-Алтай аймаг дахь Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга Н.Алтантуяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг (худалдахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Акталж, данснаас хасаж сэлбэгээр худалдсан автомашины улсын дугаарыг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗУИН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Төрийн ёмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2019 оны 12 дугаар сарын
өдрийн 6 дугаар тогтоолын хаворалт

**Говь-Алтай аймаг дахь Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртэлтэй,
актаж, сэлбэгээр худалдах автомашини жагсаалт**

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар | Ашиглалтад орсон он | Нийт гүйлт /км/ | Балансын анхны үнэ (төгрөгөөр) | Хурумтлагдсан элэгдэл (төгрөгөөр) | Үлдэгдэл ертөг (төгрөгөөр) | Сэлбэгээр ашигласнаас олох орлогын доод хэмжээ |
|-----|---|---------------------|-----------------|--------------------------------|---|----------------------------|--|
| 1 | Уаз фургон, 7811 ГАА арал-10053308, хөдөлгүүр-0007370 | 2000 | 37520 | 7,382,270.00 | 7,382,270.00 | 0.00 | 500,000.00 |
| | Дүн | | | 7,382,270.00 | 7,382,270.00 | 0.00 | 500,000.00 |
| | НИЙТ | | | | 7,382,270 (долоон сая гурван зуун наян хоёр мянга хоёр зуун далан) | 0.00 | 500,000.00 (таван зуун мянга) |